

Хэсэг 6

Монгол улс: сонгуульд нэрээ дэвшүүлэх эрхээ эдлэх нь

Цэдэвдамбын Оюунгэрэл

Редакторын тайлбар: Ц.Оюунгэрэлийн энэхүү илтгэл ерөнхийлөн тоочих, иш татах, гэр бүлийн түүхээс жишээ татах зэргээр илтгэлийн хэвимэл хэлбэрээс өөрөөр бичигдсэн сонирхолтой илтгэл юм. Ц.Оюунгэрэлийн бүтээл Монголд хамгийн их борлуулалттай байдаг бөгөөд тэрээр амжилттай яваа зохиолч төдийгүй Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр хүндтэй, бодлогын зөвлөх хэмээн үнэлэгддэг байна. Тэрээр илтгэлдээ Зөвлөлтийн үеэс өнөөг хүртэлх сонгууль болон улс төрийн суудлын төлөөх тэмцлийн талаарх сонирхолтой баримтуудыг дэлгэсэн байна. Коммунист намын “дарангуйллаас” “ардчиллын” замд шилжсэн тухай “сайн мэдээ”-ний түүх нь үнэн бөгөөд нарийн ялгаа, егөөдлийг агуулжээ. 1990-ээд оны үед сонгогдох гэдэг ойлголт нь өнөөдрийнхөөс арай өөрөөр ойлгогдож байсан юм. Өнөөгийн Монгол дахь “сонгогдох” гэдэг ойлголт нь хэн бүхний хүлээж буй ардчиллын сонгодог хэлбэрээс өөр байдлаар ойлгогддог. Бүхэлд нь дүгнэж хэлэхэд, Ц.Оюунгэрэл бидний мэдрэхүй болон хүлээлтийг хэт хялбар төсөөлөлтэй байхаас болгоомжлуулж, анхааралтай байж Монголын улс төрийн үйл явц, онцгойрол, тэмүүллийн хошигнолыг хүндлэх хэрэгтэйг сануулсан байна.

Монголын сонгууль 1960-аад онд: Социализмын үе

- Сонгуулийн хуудсанд нэг л хүний нэр бичигдсэн байна;
- Намаас өгсөн зааврыг үг дуугүй дэмжих хүн нэр дэвших магадлалтай;
- Нэр дэвшигч өөрийн санал бодолоо илэрхийлэх, тэр ч бүү хэл бодлого боловсруулах талаар мэдлэгтэй байх албагүй;

- Нэр дэвшигч хөдөлмөрийн талбарт манлайлагч, “ажилчин” гэр бүлээс гаралтай байх;
- Нэр дэвшигчээс ямар ч зардал гарахгүй бөгөөд сонгуультай холбоотой бүхий л зардлыг нам (магадгүй төр) даадаг;
- Сонгуулийн үеэр сонгогчидтой уулзалт хийх боловч нэр дэвшигч асуултуудад хариулах шаардлагагүй, намаас томилсон төлөөний хүн түүний өмнөөс ярина;
- Өрсөлдөөн байхгүй, 99-өөс илүү хувийн саналаар баталгаатай сонгогдоно.

ЖИШЭЭ:

Лувсангийн Цэдэвдамбын 1960 оны сонгуулийн сурталчилгааны хуудас:

“Лувсангийн Цэдэвдамба нь 1932 онд Хөвсгөл аймгийн Тариалан сумын малчин гэр бүлд төржээ. Тэрээр 1975 онд Монгол ардын хувьсгалт намд гишүүнээр элссэн. 1956 онд тракторчны курсд сурч төгссөнөөсөө хойш тэрээр Тариалан сумын сангийн аж ахуйд тракторчнаар ажиллаж байна.

Цэдэвдамба нь 1956 онд ДТ-54 трактор хүлээн авч, өөрийн хариуцсан техникийг чадварлагаар эзэмшин, арчлан хэрэглэж, хайр гамтай ашиглан, ажил хөдөлмөрөө эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүрэг хэмээн ухамсарлан үнэнч шударгаар үнэн сэтгэлээсээ хөдөлмөрлөн, жилийн төлөвлөгөөгөө 155-157.7%-иар хангаж, шатахуун хэмнэн, трактораа арчлан жилдээ 415 to 12,400 төгрөгийн хэмнэлт гаргаж байна. ...”

“...Сонгогчид оо! Намын гишүүд болон нам бусчуудын эвлээс нэрийг нь дэвшүүлсэн Лувсангийн Цэдэндамбын төлөө саналаа өгцгөөе!”

Нэмэлт мэдээлэл: Ардын их хурлын тэргүүлэгчид хуулийн төслийг хэлэлцдэггүй бөгөөд намаас өгсөн удирдамжийн дагуу санал өгдөг байв.

1990- 2008 он:

- Сонгуулийн хуудас дээр хэд хэдэн нэр дэвшигчийн нэр бичигдсэн байна;
- Нэр дэвшигч бусдаас ялгаарах, өөрийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлэх чадвартай юмуу найз нөхөд / хамаатан садан/ дэмжигч олонтой байх ёстой. Гэнэт од болж тодрох хүмүүс олон;
- Нэр дэвшигч бодлого боловсруулах талаар мэдлэгтэй байх шаардлагатай;
- Нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлаа санхүүжүүлэх мөнгөтэй байх, эсвэ хөрөнгө босгох ёстой. Дээрх хугацааны туршид хөрөнгө босгох үйл ажиллагаа ил тод бус байлаа;
- Шинээр нэр дэвшигч сонгуультай холбоотой зардлын дийлэнх хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх ёстой бөгөөд намын, магадгүй төрийн эх үүсвэрээр зөвхөн зарим үйл ажиллагааг л санхүүжүүлнэ;
- Намаас нэр дэвших эрхтэй болохын тулд нэр дэвшигч эхлээд намд мөнгө төлөх шаардлагыг улс төрийн намууд шаарддаг.
- Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны үеэр сонгогчидтой хамаагүй олон бөгөөд идэвхтэй уулзах болж, өөрийн болон намын хөтөлбөрийг сурталчлан таниулах үүрэгтэй;
- Жижиг болон алсагдсан орон нутагт сонирхлын зөрчил, танил тал, садан төрлийн хүнээ дэмжих явдал газар авсан;
- Нэр дэвшигч ялалт байгуулах эсэх нь баталгаагүй

ЖИШЭЭ

Сонирхлын зөрчил, танил талаа дэмжих явдал гүнзгийрсэнийг Баян-Өлгий аймгийн Толбо сумын 2008 оны сонгуулийн үр дүн тодорхой харуулж байна. Толбо сум нь х

нийслэлээс хамгийн их алслагдсан Баян-Өлгий аймгийн төв Өлгийн хотоос 76 километрт оршдог

Энэ сум иргэдийн төлөөлөгчөөр 20 хүнийг сонгосноос 11 нь Хурлын Тэргүүлэгчээр сонгогджээ. ИТХ нь сонгуульт дөрвөн жилийн хугацаандаа жилд нэг л удаа хуралддаг бол Хурлын Тэргүүлэгчид үүнээс хамаагүй олон удаа хуралддаг байна. Толбо сумын ИТХ-ын 20 гишүүний олонх болсон дараах 11 гишүүн, мөн хурлын тэргүүлэгчдийн олонх болсон зургаан хүн дараах байдлаар бие биетэйгээ холбоотой байлаа:

1. Хабил Шарив, сумын Монгол Ардын Нам буюу МАН (хуучнаар МАХН)-ын үүрийн дарга;
2. Адилбек Шарив, МАН, Хабилын дүү;
3. Хуят Шарив, МАН, Хабилын дүү;
4. Шарив Сабит, МАН, Хабилын хадам аав;
5. Клалшхан С, МАН, Хабилын үеэл;
6. Лейхан Бугубай, Ардчилсан Нам буюу АН, орон нутгийн АН-ын манлайлагчдын нэг болох ах;
7. Жайдарман Бектемир, АН, Б. Садетын үеэл;
8. Эгүнбайн Талант, АН, Б. Садетын нагац ах;
9. Хүлүнбайн Марат, АН, Б. Садетын нагац ах;
10. Марат Саминхан, МАН, сумын ИТХ-ын одоогийн дарга;
11. Өнерхан Самихан, МАН, Марат Саминханы ах.

Хуят (№3)-ын эхнэр, Хабил (№1)-ын бэр Хамкеш Толбо сумын ИХТ-ын нарийн бичгийн алба хашдаг. Сумын түвшинд үүсэж байгаа ийм маягийн садан төрлийн хэлхээ холбоо нь сонгуулийн тойрог жижиг, мөн нэр дэвшигчээс ёс зүйтэй байхыг шаардсан эрх, үүргийн зохицуулалт байхгүй байгаагийн үр дүн юм.

2012:

- Өнөөдрийг хүртэл эрх зүйн орчин бүрхэг;
- Шинээр нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч болон жижиг намуудад хүнд;

- Эмэгтэйчүүд болон боломж бололцоо муутай нийгмийн бүлгүүдэд хүнд. Учир нь улс төрийн намуудын шаардаж байгаа их хэмжээний мөнгийг төлж чадахгүй;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлбөртэй сурталчилж , улс төрчид хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг эзэмшиж байгаа орчин нөхцөл нэр дэвшихэд маш их зардал шаардлагатай;
- Сонгуулийн будлианы янз бүрийн арга хэлбэрийн талаар хүмүүс мэддэг болсон.